

ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.7-д "Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно." гэж тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн явцад тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар холбогдох байгууллагуудын саналд үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгалаа. Үүнд:

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг харгалзах зохицуулалтыг нэмж, ингэснээр олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах нөхцөл бүрдэнэ гэж үзлээ.

-Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтад "Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно." гэж заасан бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, түүний үзэл баримтлалд нийцүүлэн хууль бус ард нийтийн санал асуулга явуулахыг гэмт хэрэгт тооцохтой холбогдсон нэмэлтийг Эрүүгийн хуулийн Арван есдүгээр бүлэгт оруулах зайлшгүй шаардлага бий болсон.

Ийнхүү Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуульд нэмэлт орж байгаатай холбогдуулан энэхүү гэмт хэргийг тагнуулын байгууллага мөрдөн шалгах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмж тусгав.

Мөн Улсын онц чухал объект, онц чухал мэдээллийн дэд бүтцийн байгууллага, байгууламжийн үйл ажиллагаанд саад учруулах гэмт хэргийн харьяаллыг тагнуулын байгууллагад хамааруулах, сонгуультай холбоотой хэргийн харьяаллыг цагдаагийн байгууллагад шилжүүлэх өөрчлөлтийг тусгаад байна.

-Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд холбогдох үйл баримтын маргаангүй хэргийг хянан шийдвэрлэх журмыг зохицуулсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь хүний зөрчигдсөн эрхийг түргэн шуурхай сэргээж, улмаар шүүхийн байгууллагын хэвийн ажиллах нөхцөлийг хангаж, бусад маргаан бүхий хэргийг талуудын тэгш эрх, мэтгэлцэх зарчмын дагуу хянан хэлэлцэж, хуулийн дагуу үндэслэлтэй шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой билээ.

Иймд гэм буруугаа хүлээн зөвшөөрч, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход бодитой дэмжлэг үзүүлсэн, хохирлоо нөхөн төлсөн, эсхүл хохирол нөхөн төлөхөө илэрхийлсэн хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг үйл баримтын болон эрх зүйн маргаан бүхий ердийн журмаар хянан шийдвэрлэх хэргээс ялгамжтайгаар хөнгөрүүлж тогтоох, мөрдөн шалгах болон шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг илүү хялбарчлах шаардлагатай талаар хуулийг хэрэгжүүлэгч байгууллагууд саналыг үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван долдугаар бүлэгт заасан Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох өөрчлөлтийг хийлээ.

Хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны дэг болон шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал, журмыг Улсын Дээд шүүх батлахаар тусгаад байна.

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг шуурхай явуулах, хохирогчийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх зорилтыг хангах үүднээс мөрдөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг дуудан ирүүлэх болон албадан ирүүлэх эрхийг нэмэв.

- Эрүүгийн хэргийн нотлох баримт бүрдүүлэх ажиллагааны 60-70 хувийг мэдүүлэг авах ажиллагаа эзэлдэг бөгөөд хэргийг шуурхай шалгаж шийдвэрлэх ялангуяа цар тахал, онц байдал зарласан үед иргэдээс мэдүүлэг авахад хүндрэл учирч улмаар хэргийн шалгалтын ажиллагаа удааширч, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байх зорилт хангагдахгүй байгаатай холбогдуулан зайлшгүй тохиолдолд мөрдөгч техник технологийн дэвшлийг ашиглан цахим хэлбэрээр хэргийн оролцогч нараас мэдүүлэг авах, авсан мэдүүлгийг нотлох баримтын хэмжээнд үнэлэх зохицуулалтыг тусгав. Ингэхдээ мэдүүлэг авахдаа дүрс харж ярих боломжтой холбоо мэдээллийн хэрэгсэл ашиглаж авах, дуу-дүрс харж, мэдүүлэг авах ажиллагааны журмыг Улсын ерөнхий прокурор батлах нэмэлтийг тусгав.

Цаг үеийн нөхцөл байдал үүнийг шаардаж байгаа бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цаг алдахгүй явуулахад онцгой ач холбогдолтой байгааг харгалзан шинээр уг зохицуулалтыг тусгаж байна.

Түүнчлэн эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулсан лавлагаа, тодорхойлолтыг нотлох баримтад тооцох, ингэснээр эрүүгийн процессын хугацаа, зардал, хүн хүчний нөөцийг хэмнэх боломжтой гэж үзсэн болно.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг шуурхай хангахад мөрдөгч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байж хангах боломж бүрдэнэ. Энэ нь тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд шуурхай шийдвэр гаргах гаргах нөхцөлийг бүрдүүлэх, хууль зүйн чухал учир холбогдолтой. Ийм учраас "тодорхой үйл ажиллагаа явуулах", "албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх", "хязгаарлалт тогтоох, цагдан хорих" таслан сэргийлэх арга хэмжээг хэвийн хэрэгжүүлэхэд 24 цагаар жижүүрлэн ажиллах шүүхийн зохион байгуулалтын талаар хуульчлан тогтоох

Тасралтгүй ажиллах шүүхийн уг зохион байгуулалтын уг чиглэлийн үйл ажиллагаа явагдаж эхэлснээр шүүхийн өмнөх шатанд үүсдэг тодорхой хүндрэлүүд шийдвэрлэгдэнэ. Тухайлбал, тухайн төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг авахад

шүүхийн үйл ажиллагаа тасралтгүй явагдсанаар зөвшөөрлийг амралтын болон бүх нийтээр амрах өдрүүдэд авч хэрэгжүүлэх, улмаар шүүхийн өмнөх шатны зорилтыг хангах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт шуурхай хэрэгжих нөхцөл бүрдүүлэх үүднээс 24 цагийн шүүх ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлэх зохицуулалтыг хуульчлав. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан аливаа хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн хэр хэмжээг тогтоох, хохирогчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалахад уг зохицуулалт чухар учир холбогдолтой юм.

-Яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг битүүмжлэх нь хуулийн этгээдийн бизнесийн хэвийн үйл ажиллагааг саад учруулахад хүргэж, улмаар энэ нь хуулийн этгээд, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг зөрчихөд хүргэдэг тул эдгээрийн эрх ашгийг хамгаалах үүднээс эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгагдаж байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагааг нэн тэргүүнд зогсоох, саад учруулахгүй байх зохицуулалтыг тусгалаа.

Тухайлбал, хуулийн этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэхэд тухайн хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтны, эсхүл хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийсэн яллагдагч, шүүгдэгчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.4-т заасан таслан сэргийлэх арга хэмжээг давхар хэрэглэх бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй гэж үзвэл тухайн хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх нөхцөлөөр хангах зохицуулалтыг тусгаад байна.

-Таслан сэргийлэх арга хэмжээний үр нөлөөг харгалзан хувийн батлан даалт авах таслан сэргийлэх арга хэмжээг нэмж тусгав.

-Эрүүгийн хуулийн 22.1, 22.4, 22.8 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй байх, авлигын хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, мэргэшсэн шүүгчээр шийдвэрлүүлэх үүднээс давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэдэг байх, давж заалдах эрхийг Улсын дээд шүүхэд хангах бодлогыг баримтлан холбогдох өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгалаа.

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ, хязгаарыг тогтоосноор нийгмийн нийтлэг хүсэл зориг хангагдах, улмаар шударга ёсыг тогтоох төрийн үйл ажиллагааны үзэл санаа хангагдана гэж үзэж байна.

Авлигын хэргийг анхан болон давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн талаар прокурорын байгууллагаас ирүүлсэн мэдээллээс дурдахад, анхан шатны шүүхээс авлигын гэмт хэрэг 2019 онд 42 хэрэг шийдвэрлэснээс 25 хэрэгт давж заалдах гомдол, эсэргүүцэл гарч, үүний 16 хэргийг, 2020 онд 99 хэрэг шийдвэрлэснээс 47 хэрэгт давж заалдах гомдол, эсэргүүцэл гарч, үүний 24 хэргийг, 2021 онд 154 хэрэг шийдвэрлэснээс 66 хэрэгт давж заалдах гомдол, эсэргүүцэл гарч, үүний 41 хэргийг давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүх болон прокурорт буцаасан, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан мэдээлэл байна. Өөрөөр хэлбэл анхан шатны шүүхээр шийдвэрлэж байгаа авлигын гэмт хэргийн 50% орчим нь давж заалдах шатны шүүх рүү очиж, тэдгээрийн мөн тал хувь нь анхан шатны шүүх рүү буцаах, шийдвэрт өөрчлөлт орж байгаа үзүүлэлт байна.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байсан хүндрэл бэрхшээл, хэрэгжүүлэхэд нөлөөлөх сөрөг үр дагавар арилж, мөрдөн шалгах

ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх ажлын үр дүн дээшлэх болно.

Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэхээр Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасны дагуу тус яамны албан ёсны цахим хуудсанд 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр байршуулсан болно.

Хуулийн төсөлд Засгийн газрын бүх гишүүд, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Хүний эрхийн үндэсний комисс, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын хуульчдын холбоо, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зэрэг хуулийг хэрэгжүүлдэг холбогдох бүх байгууллагуудаас саналыг авч тусгасан болно.

Хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн төслийн үр нөлөөний судалгааг холбогдох аргачлалын дагуу хийсэн бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар гарах зардал үүсэхгүй болно.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ